

УДК 811.512.31: 81`282.4

ББК 81.2Бур – 67

М906

**С. Мөнхсайхан**

**Улан-Батор, Монголия**

## **ПОЛЕВЫЕ ИССЛЕДОВАНИЯ ГОВОРОВ БУРЯТ, ПРОЖИВАЮЩИХ В МОНГОЛИИ**

Статья посвящена экспедиционным исследованиям говоров представителей бурятской диаспоры, проживающей в Монголии. В статье рассмотрены полевые материалы, собранные монгольскими учёными в 1960-1980-е годы в Дорнодском, Хэнтэйском, Селенгинском, Хубсугульском, Булганском аймаках. В работе проанализированы экспедиционные материалы по бурятскому языку, хранящиеся в Фонде национальной письменности и фольклорного наследия Института языка и литературы АН Монголии. По мнению автора, экспедиционные материалы характеризуют: 1) говор онон-улзынских бурят; 2) говор эг-уринских бурят; 3) говор селенгинских бурят; 4) говор хамниган и баргутов. Автор, отмечая, что полевые материалы по бурятским диалектам достаточно отражены в научных публикациях, вместе с тем подчеркивает, что некоторые материалы, в частности, экспедиционные материалы, собранные в 1976-1977 гг. в Хубсугульском, Булганском, Хэнтэйском, Дорнодском аймаках, до сих пор не введены в научный оборот.

**Ключевые слова:** бурятские говоры; полевые исследования; говор агинских, хоринских, селенгинских, тункинских, кударинских бурят; говор хамниган, баргутов

**S. Mönkhsaikhan**

**Ulan-Bator, Mongolia**

## **FIELD RESEARCH OF MONGOLIAN BURYATS DIALECTS**

The article gives an overview of the research of Mongolian Buryats dialects. Field materials, accumulated by Mongolian scientists between the years of 1960 to 1980 in Dornod, Khentii, Selenge, Khövsgöl and Bulgan provinces have been considered. Expedition research data on the Buryat language, memorized in the Fund of national literature and folklore, Institute of language and literature of the Academy of Sciences of Mongolia have been reviewed. The author thinks that research data characterize: 1) the dialect of Onon-Ulz Buryats; 2) the dialect of Eg-Üür Buryats; 3) the dialect of Selenge Buryats; 4) the dialect of Khamnigans and Barguts. The author states that although field research materials on Buryat dialects are sufficiently considered in scientific publications, nevertheless some of them, in particular, expedition data, accumulated between the years of 1976 to 1977 in Khövsgöl, Bulgan, Khentii and Dornod provinces have not been discussed in a scientific community.

**Key words:** Buryat dialects; field research; dialects of Aga, Khori, Selenga, Tunka and Kudara Buryats; dialects of Khamnigans and Barguts

**С. Мөнхсайхан**

**Монгол улс, ШУА-ийн**

## **МОНГОЛ УЛСЫН НУТАГТ АМЬДАРЧ БУЙ**

### **БУРИАД ЯСТНЫ**

### **ХЭЛ АЯЛГУУГ СУДАЛСАН ТУХАЙ**

Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ахмад эрдэмтэд 1960-80 оны үед Монгол орны өнцөг булан бүрт хүрч монгол хэлний бараг бүх аялгууг судалсан байдаг бөгөөд тэрхүү хээрийн шинжилгээний ангийн тайлан эдүгээ ХЗХ-ийн “Дуун ухааны сан хөмрөг”-т хадгалагдаж байна. Тэдгээр цуглуулсан

материалаас буриад аялгууг судалсан шинжилгээний ангийн тайланг тус өгүүлэлд танилцуулсан байна.

**Гол үгэс:** буриад аялгуу; хээрийн шинжилгээний байцаалт; ага, хори, сэлэнгэ, хударя болон түнхэнэй буриадуудай нутаг аялгуу; хамниган ба баргачуудай нутаг аялгуу

Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн 1950-иад оны эхэн үеэс хөдөө орон нутагт аман зохиол, нутгийн аялгуу судлах, сурвалжлан цуглуулах шинжилгээний ангийг жил бүр томилон тогтмол явуулах болсноор бичмэл болон соронзон бичлэгийн сан хөмрөгийг шинээр үүсгэж, эдгээр хэрэглэглэхүүнүүдээ судалгааны эргэлтэд оруулах, хадгалах, хамгаалах ажлыг албан ёсоор эхлүүлжээ. Үүний зэрэгцээ нутаг нутгаас ардын билэг авъяастнуудыг урин ирүүлж, тэдний хэлсэн үлгэр туульс, дуулсан дуу болон бусад өвийн зүйлийг соронзон туузанд шингээн бичиж хадгалах болсон байна. Энэ ажилд тус хүрээлэнгийн ахмад эрдэмтэд, академич Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв, профессор Э. Вандуй, академич Д. Цэрэнсодном, П. Хорлоо, Х. Сампилдэндэв, доктор (Sc.D) Ж. Цолоо, аман зохиол судлаач У. Загдсүрэн нар идэвхийлэн оролцож Монгол орны өнцөг булан бүрт хүрч монгол хэл бичгийн дурсгал, угсаатны зүй, аман зохиолын дурсгалыг сурвалжлан цуглуулж, монгол хэлний бүх аман аялгууг судлах ажлыг хийсэн байдаг. Эдгээр ажлын үр дүнд “Дуун ухааны сан хөмрөг”-т эдүгээ 450 хавтас бүхий 100 000 орчим хуудас шинжилгээний ангийн гар бичмэл хадгалагдаж байна.

Буриадууд нь Монгол улсын хүн амын 2.8 %, монголчуудын дотор 3 %-ийг эзэлдэг ястан юм. Хүн амын тооллогоор 1956 онд 24.6 мянга, 1963 онд 28.5 мянга, 1979 онд 29.8 мянга, 2006 онд 40.6 мянган хүн байна гэсэн статистик тоо гарчээ<sup>1</sup>.

---

<sup>1</sup> Монгол хэлний нутгийн аялгуу судлал –“Монгол улсын шинжлэх ухаан”. — №11. — Х. 89

Монгол улсын буриад аялгуугаар ярилцагчид нь Дорнод, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудад зонхилон, Улаанбаатар, Чойбалсан, Өндөрхаан, Дархан, Эрдэнэт хотуудад цөөн тоогоор ажиллаж амьдарч байна. 2006 оны байдлаар 40 000 хүн бүртгэгдсэн байна. Үүнээс Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Эрээнхороо, Чулуунхороот, болон Чойбалсан хотод Агын аман аялгуутан, Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт, Норовлин сум, Өндөрхаан хотод Хорийн аман аялгуутан буюу Онон-Улзын аман аялгуутан аж төрж байна. Мөн Хэнтий аймгийн Батширээт суманд хэсэг өрх айл Худир буриад аман аялгуутан, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сум, Уялга нутаг, Сүхбаатар, Дархан, Улаанбаатар хотод Цонгоол аман аялгуутан, Булган аймгийн Тэшиг суманд Санагын аман аялгуутан, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Хатгал, Ханх суманд Түнхэн аман аялгуутан тус тус амьдардаг<sup>2</sup> байна.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс арваад удаа<sup>3</sup> хээрийн шинжилгээний ангиар явж Сэлэнгэ, Ерөө голын цонгоол буриад, Хэнтий Дорнод аймгийн Онон, Улз голын ага, хори, хамниган, барга буриад, Хөвсгөл, Булган аймгийн Эг, Үүрийн голын санага, түнхэн буриадын аялгууг судалж байв<sup>4</sup>. Үүнийг явсан он цагийн дарааллаар танилцуулъя.

***1962 онд Хөвсгөл, Булган аймгийн зарим нутгаар явсан аялгуу, аман зохиол судлалын шинжилгээний анги<sup>5</sup>.*** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс томилогдсон тус шинжилгээний анги<sup>6</sup>-ийн зорилго нь

1. Хөвсгөл нуур орчмын дархад, хөршлөн нутаглагч халх, буриад, урианхай зэрэг ястны хэл аялгуунд ажиглалт хийх
2. Аялгуу, аман зохиол, угсаатны зүйн хэрэглэгдэхүүн, ном судрын цуглуулга хийх

<sup>2</sup> Гантогтох Г. Буриад аялгууны толь. - Улаанбаатар, 2010. — Х. 5

<sup>3</sup> Цолоо Ж. 1962, 1976, 1998 онд Хөвсгөл, Булган аймагт, 1977 онд Сэлэнгэ аймагт, 1977, 1990 онуудад Хэнтий, Дорнод аймагт тус тус ажилласан / Ж. Цолоо. Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. - Улаанбаатар, 2011. — Х. 248 / гэж тэмдэглэсэн бол, Гантогтох Г. 1976, 1979, 1980, 1982, 1983 онд Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймагт ажилласан гэж тэмдэглэжээ / Г. Гантогтох. Буриад аялгууны үгийн сангийн бүрэлдэхүүний онцлог. - Улаанбаатар, 1993. — Х. 5, дэд докторын диссертаци

<sup>4</sup> Цолоо Ж. Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. — Улаанбаатар, 2011.

<sup>5</sup> Уг тайлан Хэл зохиолын хүрээлэнгийн “Дуун ухааны сан хөмрөг”-т 2 дугаартай хадгалагдаж байна.

<sup>6</sup> Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд академич Б. Ринчен, ЭША Ч. Содном, Б. Лувсан, Б. Сумьяабаатар, МУИС-ийн оюутан М. Шинэхүү, Сүхбаатар, жолооч Лхагваа нар байв.

болно. Шинжилгээний анги Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд 6.29-7.6-ыг хүртэл, Булган аймгийн Тэшиг суманд 7.14-7.15-ны хооронд ажиллаж Цагаан-Үүр, Тэшиг сумдад амьдарч буй буриад ястны хэл аялгууны талаар дараах зүйлийг тэмдэглэн авчээ.

Одоогийн Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Булган аймгийн Тэшиг суманд олон тооны буриадууд нутаглан амьдарч байна. Зарим нь өөрсдийгөө буриад гэхгүй **bar`adă** гэж нэрлэж байгаа нь маш сонин хэрэг. Энэ буриадууд монгол гэрт бараг суудаггүй. Монгол гэрийн хэлбэрээр дөрөв, зургаа, найман ханатай модон байшин бариад, түүнийгээ дөрөв, зургаа, найман ханатай гэр гэж ярилцах юм. Нутгийн буриадуудын дотор **moŋgeŋ bar`adă, tönköŋ bar`adă, Санагын буриад, Нуртын буриад** олонх нь байна. Буриадын аман аялгуунд орчин цагийн бичгийн хэлний нөлөө нэлээд орж байгаа юм байна. Монголын бичгийн хэл ба **bar`adă** аман аялгууг харьцуулан үзвэл дараах авианууд тохирон харьцаж байна.

<i>Мон.бич.хэл</i>	<i>bar`adă ам.аял</i>		<i>Жишээ</i>
“и”	e	ширдэг	šerdëg
		билүү	beleü
“у”	ö	удвал	ödwöl sesëg
“ц”	s	цөцгий	süšegè
“ч”	š	чөдөр	šödör
		хайч	xaéšă
“ш”	tš	шанага	tšanayaă
“с”	h	зүс	dzühě
		ус	uhañ
“х”	š	эрих	erešë
“о”	u	могой	mogui

Халхчуудын -га хэлж байгаа газар буриадууд -ag хэрэглэх нь үзэгдэнэ. Жишээ нь,

*Ор.цаг.бич*

*bar`adă ам.аял*

хайрга hairag

халх, дарьгангын урагшилсан -га-тай “айргаа” гэдэг үгийг “airGa” гэж дуудаж байна. Мөн уул аман аялгуунд – γ, -l харилцан байраа солих явдал байна. Жишээ нь,

*Op.цаг.бич* *bar`adā ам.аял*

хадгалаад xadalyādā

Үгийн сангийн талаар тэмдэглэн өгүүлүүштэй зүйл нь:

n`jaltag Юм наадаг чанасан гурил

mugui Модны дархан сүхээ модон дээр тавиад цохьдог муна

bilēmerē хөхүүр

xötsò Шургааг хооронд нь чагталж хийсэн хашаа (байшин,

хадлангаа малаас хамгаалах, гол руу мал гаргахгүй гэж хийнэ)

xötsòlöh барих

jan`tsañ байшингийн тааз

хaryanai тогооны шүүр

xandžā төмөр зуух

šùñk зуухан дээр тавьж цайны сүү хөөрүүлдэг ширмэн сав

péšě шавар пийшин

xòlai яндан

sereg морины уяа

xawtsàrā жааван

džjanγai мод тавьж хөрөөддөг ац мод

xíěxě ээмэг

baláxañ зуух

segé гүүний айраг

xögröngö үнээний айраг

*1970 он Хэнтий, Дорнод аймагт ажилласан шинжилгээний анги.*

1970 оны 5-6-р сард Э. Вандуй ахлагчтай аман зохиол, аман аялгууны шинжилгээний анги Хэнтий, Дорнод аймагт явж ажилласан байна. Зорилго нь халхын дорнод ба төв аман аялгууны заагийг тогтоох, мөн буриад, хамниган, барга аялгууны талаар нэмэлт материал цуглуулах байв<sup>7</sup>.

Шинжилгээний анги 1970 оны 6 сарын 8-нд Дорнод аймгийн Баяндун суманд очиж байцаалт хийжээ. Сумын түүхчилсэн мэдээнээс үзвэл Дорнод аймгийн Баяндун сум нь хуучнаар Цэцэнхан аймгийн Ачит бэйсийн Улз голын хошуу гэдэг нэртэй байв. 1970 оны байдлаар хүн ам нь 1645, 83 % нь буриад, 17 хувь нь халхууд амьдардаг, 2010 оны байдлаар 2800 хүн амтай гэжээ. Шинжилгээний анги Дашдоногийн Гонгор, Очирын Цэдэнжав, Дугарын Балбар, Дагвын Дампил зэрэг хүмүүсийн хэлсэн үгсийг тэмдэглэж авсан нийт 12 хуудас материал байна. Жишээ нь, *zuhalaŋ*, *bäësa*, *biheleg* (бэлзэг), *oho* (ус), *tsomxo* (нуруу), *xanza* (авдар) гэх мэт.

Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд 1970 оны 6 сарын 16-нд ажилласан байна. Хуучны Хан хэнтэй уулын аймгийн Халхголын буриад хошуунд багтаж байсан. 1970 оны байдлаар хүн ам 3000, үүний 90 % нь буриад, бусад нь халх, барга, үзэмчин байв. 2010 оны байдлаар хүн амын тоо 3080. Уг суманд амьдарч байгаа буриадууд нь 1924 онд Монголын харьяат болж, 1930 онд Цагаан-Овоо суманд нүүж иржээ. Э. Вандуй гуайн тэмдэглэснээр энэ суманд бодонгууд, цагаангууд, шарайд, хүбдүүд, хуасай омгууд байдаг, 1910 оны орчим нүүж ирсэн гэжээ. Мөн буриад аялгууны үгсийг тэмдэглэсэн 16 хуудас материал байна. Жишээ нь, *šix*, *šödxör*, *hüxe*, *haxal*, *haxūhaŋ*, *žāxaŋ*, *sāšā* гэх мэт.

Шинжилгээний ангийхан Дашбалбар суманд 6 сарын 10-нд ажилласан байна. Уг сум хуучнаар Хан Хэнтэй аймгийн Улз голын буриад хошуунд харьяалагдаж байв. 1970 оны байдлаар хүн амын 99 % нь буриадууд байв. 2013 оны байдлаар 90 % нь буриадууд байна. Ага буриад Чойдог, Сойзогмаа, Жамбал, Цэвэгмид нараас бичиж авсан буриад аялгууны үгсийг тэмдэглэсэн

---

<sup>7</sup> Хэл зохиолын хүрээлэнгийн “Дуун ухааны сан хөмрөг”-т 7 гэсэн дугаартай хавтасанд энэхүү материал хадгалагдаж байна.

10 хуудас материал байна. Жишээ нь, *naḡaw* (хоншоорын уг), *jalā* (жижиг), *urgūi* (яргуй), *sox*, *soṣox*, *dūriāhaṅ* гэх мэт.

1970 оны 6 сарын 5-нд шинжилгээний ангийнхан Дорнод аймгийн Баян-Уул суманд халх, буриад аялгууны материал цуглуулжээ. Баян-Уул сум нь хуучин Хан Хэнтэй аймгийн Улз голын буриад хошуу байв. 1970 оны байдлаар хүн ам нь 3751, үүнээс халх 15.3 %, буриад 83.8 %, бусад ястан 0.8 % байжээ. Уг сумын буриадууд 1910-1920 оны хооронд Орос улсын Агын аймгаас нүүж ирсэн байдаг. 2010 оны байдлаар 3810 хүн амтай байна. Тайланд *xuṅgereg* (хунгар), *ögõx* (ерөөх), *šexe* (шулуун), *hönö*, *baxa*, *talxaṅ* (гурил), *hiṅi* (эсгий) гэх мэт буриад аялгууны үгийн санг тэмдэглэсэн 10 хуудас материал, үүн дотор мөн мөн буриад хамниган хоёр аялгууны үгийг харьцуулан тэмдэглэсэн 3 хуудас байна. Жишээ нь,

<i>буриад</i>	<i>хамниган</i>
<i>hux</i>	<i>sux</i>
<i>adūha</i>	<i>adū</i>
<i>xažūr</i>	<i>xadūr</i>
<i>mõlhõṅ</i>	<i>mõs</i>
<i>šiwāha</i>	<i>bās</i>
<i>hīlex</i>	<i>sīlëx</i>
<i>üwül</i>	<i>ögöl</i>

**1976 онд Хөвсгөл, Булган аймагт ажилласан шинжилгээний анги**<sup>8</sup>. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн төлөвлөгөө ёсоор 1976-1980 онд хийхээр төлөвлөсөн “БНМАУ-ын нутгийн аялгуу” гэдэг хамтын бүтээлийн халх, буриад аялгуу гэсэн бүлэгт холбогдох үндсэн материал цуглуулах зорилготой шинжилгээний анги 1976 оны 9-р сарын 22-ноос 10-р сарын 23 хүртэл Хөвсгөл, Булган аймагт 30 хоног ажиллажээ.

---

<sup>8</sup> Хэл зохиолын хүрээлэнгийн “Дуун ухааны сан хөмрөг”-т 13 дугаартай хадгалагдаж байна. Нийт 152 хуудас материал байгаа нь бүгд нэр дурдсан аймагт амьдарч буй буриадуудын хэл аялгууны материал, аман зохиолын хэрэглэгдэхүүн, гэрэл зураг байна. Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд эрдэм шинжилгээний ажилтан Ж. Цолоо, дадлагажигч ажилтан Д. Өлзийбаяр, туслах ажилтан Г. Гантогтох, жолооч Батхуяг нар оржээ.



Монгол хэлний халх, ойрадын аялгуу, аман аялгуу, салбар аман аялгууг нэлээд сайн судалсан боловч буриад аялгууг ангилан судлах шинжилгээний наад захын баримт учир дутагдалтай байгаа учир шинжилгээний анги Хөвсгөл аймгийн Ханх, Цагаан-Үүр, Тариалан сум, Булган аймгийн Тэшиг суманд хэсэг бусгаараа суудаг буриадын хэл аялгууны тухай материал цуглуулах ажил хийжээ.


Хөвсгөл, Булган аймагт нийтдээ 4000 орчим буриад хүмүүс амьдарч байна. Хөвсгөл аймгийн Ханх, Цагаан-Үүрийн буриадууд Түнхэн буриад бөгөөд Цагаан-Үүрийн зарим нутаг, Тэшиг сумын буриадууд Санагын буриад ажээ. Тэд дээрх нутагт 1912-1916 оны үед нүүдэллэж ирсэн байна. Тавиас доош насны хүмүүс буриад аялгуугаа мартжээ.

Буриад аялгууны материал цуглуулахдаа дор дурдсан гурван зорилгыг биелүүлэхээр ажиллажээ.

1. Орчин үеийн монгол утга зохиолын хэлнээс энэ нутгийн буриадын хэл аялгуу юугаараа ялгаатай болох

2. Монгол нутгийн Түнхэн буриадын хэл аялгуу, Дорнод, Хэнтий аймгийн Ага, Хорь буриадын хэл аялгуунаас ямар ялгаатай болох

3. Зөвлөлтийн (тэр үеийн нэрээр — С. М.) Байгаль нуураас баруун тийших өргөн уудам нутагт суудаг Түнхэн буриадын хэл аялгуунаас ямар ялгаатай болох зэргийг тодруулахыг зорив.

 Орчин үеийн монгол утга зохиолын хэлнээс Түнхэн, Санага буриадын аялгуу доор дурдсан хэдэн онцлогоор өвөрмөц ажээ.

а) *Авиазүйн хувьд:*

1. S-h: ус — uhaᠨ, ts-s: цонх — sonxo

2. ó, ù: òndòr~ùnder, mòndòl, sošòd~tsotšòd

3. Тодорхой хэдэн гийгүүлэгч эр эгшигтэй үгэнд хэт тагнайшдаг. Жишээ нь, тахиа — tax'ã, хяруу — x'irũ~s'irũ гэх мэт. Авиазүйн иймэрхүү ялгаатай үзэгдэл 20 гаруй юм.

б) *Хэлзүйн хувьд:*

Харьяалахын тийн ялгалын дагавар нь дараах хэлбэрүүдтэй. Үүнд

1. zasaji beleg — засгийн шагнал, төрийн шагнал

2. būni zamag — бууны замаг

3. xadòd — хад өөд

в) *Үгийн сан хувьд:*

atlǎǎ — Мод ухаж хонхойлдог багаж.

šayāwǎg — цонх. Ийм төрлийн үгийг ажиглахад гэр ахуйн эд хогшил, сав суулга, багаж зэвсэг, малын өнгө зүс заасан үгс байна<sup>9</sup>.

 Дорнод, Хэнтийн буриадын аман аялгуунаас ялгаатай тал нь

а) *Авиазүйн талаар:* Түнхэн, Санагын буриадын авианы бүрэлдэхүүний хувьд Дорнод, Хэнтийн буриад аялгуутай үндсэндээ адил боловч гийгүүлэгчийн хувьд хамжин шүргэх tš, kx хувилбараар ялгарч байна. Эл аман аялгууны хамжин шүргэх хувилбар бол халх, цонгоол буриад, ойрд, өвөрлөгч аялгууныхтай адил хэлэгдэж сонсогдох авч бүрмөсөн үйлдэх байдлын -ч, -чих дагаврын үүргээр хэлэгдэх зөвхөн тэр тохиолдолд байхаас биш чулуу, ачаа, ач, чарга, чоно гэх мэт үгийн биш болой. Жишээ нь,

**Түнхэн:** tābari martātšōb

**Санага:** nād zahādān xetštšōhōmdā

**Дорнод:** tābari martažirx'ōb

**Дорнод:** nād zahadan xežirx'ōhōmdā

**Халх:** ɔn'soɔ̆ martatšixsandā

**Халх:** nād dzaxdān xitšixsēndē

kx хувилбар нь үгүй гэсэн үгүйсгэх утгатай бүтээврийн өмнө тохиолдож байгаа нь өвөрлөгчдийн аялгуутай жишиж үзэхэд бас сонин байна.

**Түнх:** xelex<sup>kx</sup>i (хэлэхгүй)      **Өв:** xelexūweī

jawa<sup>kx</sup>i (явахгүй)      jawaxuweī

mede<sup>kx</sup>i (мэдэхгүй)      medexūweī

б) *Хэлзүйн талаар:* Ялгаа нь тийн ялгалын зарим нэг нөхцөлүүд болно.

Тухайлбал, харьяалахын тийн ялгал Gali sog, xūni xūwūŋ, būni zamag. Хэрэв g-

<sup>9</sup> Дараагийн хэсэгт шинжлээний ангид оролцсон Гантогтох Түнхэн буриад Ага, Хорь буриад аялгууны ялгаатай үзэгдлийн талаар тусгай сонсгол тавьсныг хавсаргав гэсэн боловч уг хавтасан дотор байсангүй.

ээр төгссөн үг байвал -j болж сэлгэдэг. Жишээ нь, seseji dël'bě, zasaji belëg. Гэтэл Дорнод буриад аман аялгуутан Galae sog, xünei xüwün, būGae zamag, sesegei del'bě гэх мэтээр хэлнэ.

Монгол бичигт дэвсгэрлэн ордог s зүйн дагуу d болж хэлэгддэг боловч үйлдэхийн тийн ялгалд орохдоо h-гаар хэлэгддэг ийм үзэгдэл Дорнод буриадад байхгүй. Гэтэл Түнхэн, Санагын буриад аман аялгуунд

orod → orohōr zuGālnad

zed → zehēr jaxašnad

Хамтрахын тийн ялгал Дорнод буриад аман аялгуунд -tae, -tei, -toe байдаг бол Санагад tī байна. Жишээ нь, xamtī jāba, mōr'tī xūŋ, noxoetī āēl.

в) *Үгийн сангийн талаар*: Эл нутгийнхан үгийн сангийн талаар Дорнод буриадаас өвөрмөц ялгаа ихтэй. Жишээ нь,

**халх:**            ээж аав            өлгий

**Дорнод:**        awa ežī            ūlgei

**Түн., Са:**        bābae iwī        ūwē

**халх:**            нуруулдсан өвс    өмхий хүрэн

**Дорнод:**        hūri                xūrne

**Түн., Са:**        somō                hūner

Эдгээр цуглуулсан материалуудаа эмхэтгэж үзэхэд Түнхэн, Санагын буриад аман аялгуунаас монгол хэлний дунд үеийн байдлыг хадгалсан баримт нэлээд тааралдаж байна.

*1977 онд Сэлэнгэ аймагт ажилласан шинжилгээний ангийн тайлан.* Уг шинжилгээний ангийн зорилго нь “БНМАУ-ын нутгийн аялгуу” гэдэг ганц сэдэвт зохиолын хэсэгт холбогдох буриад аялгууны зарим хэрэглэгдэхүүн цуглуулах байв. Буриад аялгууны нэг салбар болох Сэлэнгийн буриад аялгууны материал дутагдаж байсан учир шинжилгээний ангийнхан Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Алтанбулаг, Шаамар, Дархан сум сангийн аж ахуй, Сэлэнгэ аймгийн төвд ажилласан байна. Энэ нутагт цонгоол амбагад, харнууд буриад нутаглаж байгаагийн зонхилох нь цонгоол буриад байна. Сэлэнгэ аймгийн төвд

суудаг 58 настай Юндэн овогтой Дорж “Цонгоол буриад есөн эцэгтэй байжээ. Үүнд, цонгоол, харнууд, авгад, амбагад, булган харнууд, атган цонгоол гэсэн зургааг би мэдэж байна. Бусдыг нь мартжээ. Хүдэр талынх нь жинхэнэ цонгоол бөгөөд Сэлэнгэ тал нь атган цонгоол юм” гэж ярьсан байна. Зөвлөлтийн монголч эрдэмтэн Ц. Б. Будаев оросын цонгоолуудыг “1. Урлут цонгоол буюу урлуутэн, 2. Эндээ цонгоол буюу эндээтэн, 3. Ухиа наймантан, 4. Урянхат, 5. Батад, 6. Ашаавгад, 7. Абагат, 8. Шарнууд, 9. Номоход, 10. ?<sup>10</sup>, 11. Хамниган, 12. Очарцудтан, 13. ?, 14. ?, 15. Амалайтан, 16. Настан, 17. Хүрбэтэн, 18. Самбилтан, 19. Бунитан, 20. Далайтан гэх зэргээр хорь гаруй овог аймгаас бүрдэнэ<sup>11</sup>” гэжээ. Эдгээр цонгоолууд нь “17-р зууны сүүлчээр Монголын Түшээт хан аймгийн нутгаас нүүдэллэн ирж Байгалийн өмнө суурьшин суусан цонгоол, удон, хатгин овгийн хүмүүс”<sup>12</sup> юм. Үүнийг батлах түүхэн баримт бол “Цонгоол овгийн гарал үүсэл” номд “1696 онд Түшээт хан аймгийн эзэмшил албат нараас зайсан Ухинаар толгойлуулсан 150-иад монгол хүмүүс нүүдэллэн явжээ. Тэд монголын цонгоол, хорчин, Йюншиэбэ овог ястан”<sup>13</sup> гэж тэмдэглэсэн байдаг. Эдгээр баримтуудаас үзэхэд ЗХУ-ын буриадын нутагт суугаа цонгоолууд 17-р зууны сүүлчээр Монголоос нүүдэллэн гарсан хүмүүс ажээ. Тэгвэл эдүгээ Сэлэнгэ аймагт суугаа цонгоол буриадууд ЗХУ-д нүүдэллэн очсон хүмүүсийн уг удам мөн үү? гэдэг нь анхаарах зүйл болно. Бидний уулзсан настай хүмүүс Хүдэр, Ерөө, Алтанбулагийн цонгоол буриадууд 1921 оны хувьсгалын өмнөхөн буюу дараах үед хилийн чанадаас нүүдэллэн ирсэн гэдгийг баталж байна. Иймд цонгоол буриадууд угтаа монгол газраас нүүдэллэн хилийн чанадад гарч яваад цонгоол, абагад, еншөөв нараас тасарч ирсэн эргэн хүмүүс ажээ. Урьдчилсан ажиглалтаас үзэхэд цонгоол, ашбагад, харнуудын аялгуунд ялгаа алга байна. Ингэж ангилан ярьж байгаа нь зөвхөн овог ясны холбогдолтой зүйл болон үлджээ. Уг нь эрхбиш аялгууны ямар нэг ялгаа байсан биз. Гарлын байдал, одоогийн хэлний нь бодит

<sup>10</sup> Тайланд энэ хэсэг хоосон байв.

<sup>11</sup> Будаев Ц. Б. Исследование бурятских говоров. Вып. I. – Улан-Удэ, 1965. – Стр. 152.

<sup>12</sup> История Бурят-Монгольской АССР, Т. I. – Улан-Удэ, 1954. – Стр. 101.

<sup>13</sup> Происхождение рода цонгол // Пучковский Л. С. Монгольские рукописи и ксилографы Института востоковедения. Вып. I. – М.—Л., 1957. – Стр. 135.

хэрэглэгдэхүүн, шинжилгээний ангийн чиг зорилтын үүднээс дор дурдсан аргаар цуглуулсан материалаа боловсруулж болох юм.

- *Нэгдүгээрт*, Цонгоол аялгууны хэрэглэгдэхүүнийг монгол бичгийн хэлний гол гол холбогдох хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзэх. Ингэснээр бичгийн хэл, цонгоол аялгууны холбогдох хөгжлийг тодорхойлж болох юм.

- *Хоёрдугаарт*, Хилийн цаана суугаа цонгоол аялгууны материалтай монгол нутгийн цонгоол буриад аялгууны холбогдох материалтай зэрэгцүүлэн судлах аргаар монголын цонгоол буриад аялгууны халхажсан явц болон монгол үндэсний утга зохиолын хэлний нөлөөгөөр ижилшсэн байдлыг тодорхойлох боломжтой байна.

- *Гуравдугаарт*, 1976 онд цуглуулсан Хөвсгөл, Булган аймгийн Санага, Түнхэн буриад аялгууны материалтай харшуулан үзэв. Ингэснээрээ цонгол, түнхэн, санага аялгууны төстэй шинж, газар нутгийн ойролцоо байдлаар нэгэн аман аялгууны бүлэгт багтааж болох эсэхийг тодруулах юм. Хэрэв ийм боломжтой бол цонгоол аялгууг Сэлэнгийн буриад аман аялгууны нэг салбар аман аялгуу гэж үзсэн бидний таамаглалыг батлах юм.

- *Дөрөвдүгээрт*, Монгол нутгийн зэргэлдээх Хорь, Ага буриадын аялгуутай харьцуулж болохоор байна. Ингэснээрээ монгол нутгийн нийт буриадын аман аялгуу нэг бүрийн өвөрмөц онцлог хэлний холбогдол, бас халх аялгуундаа буриадын аль аялгуу нь илүү ойрхон байгааг тодорхойлж болох байна. Эдгээр зүйлд тулгуурлан дараах дүгнэлтүүдийг урьдчилан хийж байна.

1. Цонгоол аялгуу монголнутгийн буриад аялгуунуудаас монгол бичгийн хэлнээс хамгийн холдсон аялгуу мөн. Жишээ нь,

<i>Мон.бич</i>	<i>Орч.цаг утга</i>	<i>Цонгоол буриад</i>
naɣan	naɣan — нар	nasa
odun	odon — од	odo
egüden	üden — үүд	üde
öndügen	öndögön — өндөг	öndög

2. Хилийн цаана суугаа буриадуудын хэл аялгуунаас орчин цагийн монгол хэлэнд хамгийн ойрхон нь цонгоол, сартуул аялгуу гэдэг. Гэвч хилийн чанадын

цонгоол буриадын хэл аялгууг бодвол монгол цонгоол буриад аялгуу бусад буриад аялгуунаасаа илүү халхажсан байна. Энэ нь цонгоол буриаддууд Монгол нутагт хэсэг хэсгээрээ тархан сууж байсан, энд тэнд нүүдэллэн очсон зэрэг суурьшилтай шууд холбоотой юм. Эдүгээ Ерөө сум сангийн аж ахуйд 4-5 өрх буриад айл байна. Тэдний 50-иас доош насны хүмүүс халхаар ярих бөгөөд 60 орчим насны хүмүүсийн хэл яриа халхажсан буриадын завсрын салбар аман аялгуутан болжээ. Жишээ нь, цонгоол буриадын дунд өргөн дэлгэрсэн 18 мөр 61 үг бүхий нэг дуунд хайсанхан халтар, харлахан зүрх гэсэн хоёр буриад үг байх бөгөөд бусад нь халх хүмүүсийн мэддэг үг байна.

Түнхэн буриад *hulga'* (суулга), *huxe* (сүх) гэдэг үгийн *h*-г цонгоол буриад аялгуутан *s*-ээр хэлж байна. Тэгэхдээ энэ *s* халх аялгууны цэвэр *s* биш бөгөөд *s'* буюу амьсгалын түрэлттэй *s* болно<sup>14</sup>.

3. Түнхэн, Цонгоол буриадад тодорхой хэдэн гийгүүлэгч илүү их тагнайшиж байна. Жишээ нь, *hüd*, *hurgan*, *ar'x'i* гэх мэт. Эдгээр жишээнээс үзэхэд Түнхэн, Цонгоол буриад газар нутгийн ойролцоо, хэлний зарим төстэй шинжээр нь Сэлэнгийн буриадын аман аялгууны хоёр салбар аман аялгуу гэж болох мэт санагдана.

Цонгоол буриад аялгуу Хорь, Ага буриад аялгуунаас ямар ялгаатай болохыг тодруулах нь бидний цаашдын зорилго болно. Гэвч монголын буриад аялгуунаас үндэсний утга зохиолын хэл буюу халх аялгуунд хамгийн ойрхон, илүү халхажсан нь Цонгоол буриад аялгуу гэдгийг баттай хэлж болно. Цонгоол буриадаас хувьсгалын эхэн үеийн түүхэн үйл явцыг тусгасан сэдэвтэй ялангуяа *нам, эвлэл*, Сүхбаатарын тухай нэлээд олон дуу байна. Энэ нь цонгоол аялгууны чухал хэрэглэгдэхүүн болохыг батлан, монгол шинэ аман зохиолын ховор олдвор гэж бодож байна<sup>15</sup>.

*1977 Хэнтий, Дорнод аймагт ажилласан шинжилгээний анги* <sup>16</sup> .

“БНМАУ-ын нутгийн аялгуу” гэдэг зохиолын нэгэн бүлгийн үндсэн

<sup>14</sup> Гэхдээ энэ нь монгол бичгийн хэлний 's' буюу амьсгалын онц их түрэлттэй гийгүүлэгчийн нөлөө байж магадгүй.

<sup>15</sup> Хавтасанд нийт 32 хуудас цонгол буриадын аман зохиолын холбогдолтой материал байна.

<sup>16</sup> Уг тайлан “Дуун ухааны сан хөмрөг”-т 297 гэсэн дугаартай хадгалагдаж байна. Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Ж. Цолоо, Ж. Сэржээ, Г. Гантогтох нар байв. Ж. Цолоо буриад аялгууны үгийн сан, Ж. Сэржээ авиазүй, Г. Гантогтох хэлзүйн үзэгдлийг судлах даалгавартай байв. Нийт 154 хуудас материал байна.

хэрэглэгдэхүүнийг цуглуулах зорилгоор 1977 оны 9-р сараас 10-р сар хүртэл Хэнтий аймгийн Батширээт, Дадал, Биндэр, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо сумдад ажилласан байна.

Шинжилгээний ангийн ажилласан нутагт ага, хорь, хамниган, цонгоол бүгд хориод мянган хүн амьдарч байна. Шинжилгээний ангийн урьдчилсан дүнгээс үзэхэд Хэнтий аймгийн Батширээт, Дадал, Норовлин, Биндэр суманд суугаа хорь буриад нь хорь арван нэгэн эцгийн уг улбаа, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Цагаан-Овоо сумын Ага буриад нь Ага найман эцгийн уг удам ажээ. Хэл аялгууны байдлаараа (ялангуяа авиазүй, хэлзүйн талаараа хоорондоо ялгарах зүйл бага юм) нэгэн бүлэг Ага-Хорийн салбар аман аялгуу гэж болмоор юм.

- Монгол бичгийн хэлний цөөн эр, эм үгийн эхэн, дунд орсон шүргэх *s* гийгүүлэгчийг хэлний гүн угийн, хөөмийн гийгүүлэгчээр дуудна. *s* гийгүүлэгчийн амьсгалын түрэлт хөөмийн *h* болжээ. Жишээ нь, *saraGul* саруул — *harúl*, *sonin* сонин — *honin*, *süke* сүх — *hüxe*, *serege* сэрээ — *heré*.

- Бичгийн хэлний бүх *s*-г энэ салбар аман аялгуунд *h*-ээр хэлдэггүй. Жишээ нь, *sansar*, *küsel*, *asúx*, *zas* гэж дуудна.

- Мөн монгол бичгийн хэлний үгийн дунд, эцэст орсон *s* гийгүүлэгчийг хэлний урдуурх *d* гийгүүлэгчээр дуудах нь бий. Жишээ нь, *зэс* — *zed*, *улс* — *ulad*, *бөс* — *bod*.

- Бичгийн хэлний *й, ё* гийгүүлэгчийг шүргэх *z, ž, s, š*-ээр хэлнэ. Зарим залуу хүний ярианд *z, ž* нь *dz, dž* болжээ. *ајил* — *ažil* — *adžil*, *цidal* — *šadal*, *цецег* — *seseg*.

- Бичгийн хэлний *и* эгшгийн өмнөх *ц* гийгүүлэгчийг шүргэх *š*-ээр *цisun* — *šuha*, *бицiqan* — *bišiqan* гэж хэлнэ.

- Бичгийн хэлний *и* эгшгийн өмнөх *г*-г *ј*-ээр хэлж *orgil* — *orjel*, *songgino* — *hoñjino* гэж дуудна.

- Нэгэн цуваанд орсон *ng, n* гийгүүлэгчийн дараалал бичгийн хэлний хэлбэрийг хадгалсаар байна. Жишээ нь, *engne* — *ehné* — *эгнээ*, *cingna* — *šajna* — *чагна*

- Бичгийн хэлний өргөлтөт үеийн *i* эгшиг дараах үеийн гэшигтэйгээ уруулшиж, уужимшиж, ижилшин өмнөх гийгүүлэгчээ тагнайшуулсан. Жишээ нь, *nidün — nũde — нүд, miqan — máxa — мах, ničügen — nũsgen — нүцгэн*

- Монгол хэлний буриад аялгууны *o* эгшиг өргөлтөт болон бусад үед огт тохиолддоггүй гэсэн зарим эрдэмтдийн саналыг хянууштай мэт санагдана. Жишээ нь, *čidür — šodor — чөдөр, čidkür — šotxor — šũdxe — чөтгөр, öndür — ondür — ũndür — өндөр*

- Бичгийн хэлний үгийн *I* үеийн урагшилсан *ü*-г *i* эгшгээр хэлдэг. Жишээ нь, *bülekü — bilex — бүлэх, büse — bihe — бүс*

- Үгийн дунд чанга гийгүүлэгчийн дараа, хоёр эгшгийн дунд тохиолдох *G* гийгүүлэгч *x*-ээр сэлгэж дуудагдана. Жишээ нь, *totuG-a — totoxo — тотго, quGarqai — хухарха — хугархай*

- Үгийн сангийн хувьд үндэсний утга зохиолын хэлэнд байдаггүй дархан мужааны багаж хэрэгслийн зүйлтэй холбоотой цөөн үг байна. Жишээ нь, *бахь — hazúr, гударга — ũšpũnte, жижиг харуул — zomGoló харул, жижиг сүх — muna, нарийн хөрөө — ewé xóroó, том өрөм — sũndrũw — sũmdũrũ, том хөрөө — zusGar xóroo, тэгш ус, тэгшлүүр — Gurwin, цүүц — hũ'ũše, эв нийлүүлж мод гаж гаргадаг харуул — ruGáñ*

- Буриадууд тэр чаргыг илүү хэрэглэдэг учир үгийн санд нь тэрэг чарганы өвөрмөц нэр томъёо бий. Жишээ нь, *toхроñ — хоёр дугуйт модон тэрэг, džoró tereg — дөрвөн дугуйтай хоёр үхэр хөллөдөг модон тэрэг, odiór — арал, šizólxo — эмээл, arma — тэвш*

## ДҮГНЭЛТ

- Дээр дурдсан урьчилсан маягтай судалгаа нь уг шинжилгээний ангиар явсан хүмүүсийн бүтээлээр нэгэнт батлагдсан бөгөөд тухайлбал, Монгол улсын нутагт амьдарч буй буриадуудын хэл аялгууг хэл шинжлэлийн үүднээс Онон-Улзын аман аялгуу, Эг-Үүрийн аман аялгуу, Сэлэнгийн аман аялгуу, Хамниган баргын аман аялгуу гэж хуваасан дээрх эрдэмтдийн саналыг судалгаанд өдий хүртэл баримталж байна. Мөн уг аялгуу нь үгийн бүрэлдэхүүн, хэл зүйн



байгуулал, язгуур үгийн шинж, үг бүтэх ёсны хувьд монгол хэлний нийтлэгт багтах ба эрхбиш уламжлалт ёс заншил, сэтгэхүйн онцлог, сүсэг бишрэл, зан үйл зэргээрээ ялгарах учир буриад аялгуу, аман аялгууны басхүү өөрийн гэсэн ялгарах үгийн сантай байдаг. Шинжилгээний ангийн ажлын үр дүнд буриад аялгууны тольд орох эх хэрэглэгдэхүүнийг бүрэн цуглуулж чадсан байна.

- Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс олон удаа шинжилгээний ангиар явж Монгол нутагт амьдардаг буриад ястнуудын хэл аялгууг судалж, үүний үр дүнд буриад хэл аялгууны талаар олон тооны судалгааны бүтээл хэвлэгдсэн<sup>17</sup> боловч сурвалжлан цуглуулсан нутгийн аялгууны бичмэл хэрэглэгдэхүүнүүд нь өдийг хүртэл шинжлэх ухааны эргэлтэд орж нийтийн хүртээл бололгүй тус хүрээлэнгийн “Дуун ухааны сан хөмрөг”-т хадгалагдсаар байна. Тухайлбал, 1976 оны Хөвсгөл, Булган, 1977 оны Хэнтий, Дорнод аймагт ажилласан тайланд буриадуудын үгийн сан, угсаатны зүйн холбоотой олон тооны материалууд тэр хэвээрээ хадгалагдаж байна.

Монгол улсын буриад хэл аялгууны судалгааг 1980-аад оны дунд үеэс хойш (ганц хоёр хүний хэсэг бусаг судалгааг эс тооцвол) бараг хийгээгүй учир ойрын жилүүдэд үр дүнтэй судалгаа хийж өмнөх үеийн судалгааны бүтээлүүдтэй харьцуулан үзвэл буриад аялгууны хувьсал өөрчлөлт хийгээд цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чухал зүйл болно хэмээн үзэж байна.

---

<sup>17</sup> Сумъяабаатар Б. Буриадын үгийн бичээс. — Улаанбаатар, 1967; Гантогтох Г. “Монгол бичгийн хэл хийгээд Монгол дахь буриад аялгуу”. — Улан-Удэ, 1993; Буриад аялгууны үгийн сангийн онцлог (дэд докторын диссертаци) Улаанбаатар, 1993, Буриад аялгууны толь. — Улаанбаатар, 2010; Ж. Цолоо. Монгол хэлний нутгийн аялгуу. – Т. I. Үгийн сан. – Улаанбаатар, 1997; Цолоо Ж., Рэгзэндорж Р. Монгол улсын буриад-монголчууд. — Улаанбаатар, 2005.